



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/243

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай

Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын шийдвэрээр олгогдох Монгол Улсын Засгийн газрын шагнал “Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ыг нэгдүгээр, “Яамны хүндэт жуух бичгээр шагнах журам”-ыг хоёрдугаар, “Салбарын түүхэн ойн хүндэт медалиар шагнах журам”-ыг гуравдугаар, “Шагнуулах хүний анкетын загвар”-ыг дөрөвдүгээр, “Шагналын үнэмлэхний загвар”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ журам гарсантай холбогдуулж Уул уурхайн сайдын 2014 оны 83, Аж үйлдвэрийн сайдын 2014 оны 03 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.СУМЪЯАБАЗАР

Уул уурхай, хүнд үйлдвэрийн
сайдын 2018 оны 11 дугаар сарын 20
ны өдрийн 1/1 тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

“САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ТЭМДГЭЭР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын шийдвэрээр олгох “Тэргүүний уурхайчин”, “Тэргүүний геологич”, “Газрын тосны тэргүүний ажилтан”, “Үйлдвэрийн тэргүүний ажилтан” тэмдгээр тухайн салбарыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, ажлын өндөр амжилт, бүтээл гаргасан тэргүүний хүмүүсийг шагнахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнуулах хүсэлтийг өмчийн аливаа хэлбэр харгалзахгүйгээр, сүүлийн 5 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага гаргаж болно.

1.3 Салбарын тэргүүний ажилтан тэмдгээр дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэн шагнана. Үүнд:

1.3.1. Шагналд нэр дэвшиж байгаа хүн геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт 12-оос дээш жил тогтвор суурьшилтай ажилласан байна.

1.3.2. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, найдвартай ажиллагааг хангах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг баяжуулах, байгаль орчинд халгүй дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх, түүнчлэн экспортолж байгаа бүтээгдэхүүний боловсруулалтын төвшинг олон улсын стандартад нийцүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зэрэгт мэргэжлийн ур чадвараа дайчлан санаачлагатай ажилласан удирдах болон инженер техникийн ажилтан, албан хаагч байна.

1.3.3. Ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж, ажил үйлчилгээг хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлэн чанартай, шуурхай гүйцэтгэж, эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, мэргэжлийн өндөр ур чадвар гарган идэвхи, санаачлагатай ажиллаж байгаа ажилчид, албан хаагчид;

1.3.4. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургахад бодитой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шинэ нээлт бүтээл гаргасан багш, эрдэмтэд;

1.3.5. Салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, төр, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмадууд, гадаадын иргэд;

1.3.6. Салбарын үйл ажиллагаанд онцгой үр дүн өгөхүйц нээлт шинэ бүтээл, оновчтой санал гаргасан, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой дэвшилтэт шинэ техник, технологийг нэвтрүүлсэн иргэд;

1.3.7. Үйлдвэрлэлд учирч болох хөдөлмөр хамгааллын зөрчил болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж, таслан зогсоох арга хэмжээ авсан, ослын хохирол уршгийг арилгах ажилд онцгой үүрэг гүйцэтгэсэн ажилтан, албан хаагчид тус тус олгож болно.

1.4. Салбарын аль нэг байгууллагад ажилладаг боловч өөрийн эрхэлсэн ажлын чиглэлээр тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулсан бол салбарын шагналыг олгохгүй.

1.5. “Журам”-ын 1.2.5, 1.2.6, 1.2.7 дахь хэсэгт заасан үзүүлэлтээр шагнагдах хүмүүст ажилласан жилийг хамааруулахгүй байж болно.

1.6. Салбарын шагнал хоорондын зай 3 жил байна.

Хоёр. Шагналыг мэдүүлэх

2.1. Шагнуулах хүний ажил байдлын тодорхойлолтыг тухайн хүний ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргах ба шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана. Уг тодорхойлолтыг хамт олны хурлаар хэлэлцүүлсэн байна.

2.2. Шагнуулах хүний материал дор дурдсан зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Байгууллагын албан тоот
- Анкет, ажлын үзүүлэлтийн хамт
- Хамт олны хурлын тэмдэглэл
- Ажилласан жилийг баталгаажуулсан тодорхойлолт /Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар болон Нийгмийн даатгалын газраас авсан тодорхойлолт/
- Салбарын аль нэг тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, жуу» бичгээр шагнагдсан бол хуулбарыг хавсаргана.

2.3. Сонгуульт болон нам, олон нийтийн байгууллага, Үйлдвэрчний эвлэлийн хороо нь гишүүд, идэвхтнээ шагнуулах саналыг тухайн ажиллаж

байсан үндсэн байгууллагад нь гаргах ба зөвхөн тухайн байгууллагын тодорхойлолт, албан бичгийг хүлээж авна.

Гурав. Салбарын тэргүүний ажилтан тэмдэг олгох

3.1. Салбарын тэргүүний ажилтан тэмдгийг энэ журмын 1 дүгээр зүйлд заасан нөхцөлийг хангасан хүмүүст салбарын онцлогийг харгалзан дараах чиглэлээр олгоно. Үүнд:

3.1.1. Геологийн салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчдыг “Тэргүүний геологич” тэмдгээр;

3.1.2. Уул уурхай, түлшний салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчдыг “Тэргүүний уурхайчин” тэмдгээр;

3.1.3. Газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчдыг “Газрын тосны тэргүүний ажилтан” тэмдгээр;

3.1.4. Хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагад ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчдыг “Хүнд үйлдвэрийн тэргүүний ажилтан” тэмдгээр;

3.2. “Салбарын тэргүүний ажилтан” тэмдгээр Монголын үндэсний уламжлалт баярууд, салбарын өдрүүд болон тус салбарын ажил үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудын 20-оос дээш жилийн давтамжтай тэгш ой болон тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан шагнах бөгөөд журмын 1.2.5, 1.2.6, 1.2.7 дахь хэсэгт заасан үзүүлэлтийг үндэслэн шагнах тохиолдолд энэ хугацаа хамаарахгүй байж болно.

3.3. Тухайн салбарт он удаан жил ажилласан ахмад ажилтан, ажилчдыг яам, харьяа агентлаг, орон нутгийн удирдлагын саналыг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын шийдвэрээр олгоно.

Дөрөв. Шагналыг дагалдах урамшуулал

4.1. “Салбарын тэргүүний ажилтан”-ны тэмдгийг дагалдах үнэмлэх, Хүндэт тэмдгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас олгох бөгөөд мөнгөн урамшууллыг тухайн хүнийг шагналд тодорхойлсон албан байгууллага хариуцна.

4.2. “Салбарын тэргүүний ажилтан”-ны тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд тухайн шагнагдсан хүний ажиллаж байгаа байгууллагын албан тодорхойлолт, ирүүлсэн өргөдлийг үндэслэн нэг удаа төлбөртэйгөөр солих буюу нөхөн олгож болно.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2018 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн
8/243 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны

“Жуух бичиг” олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 53 дугаар тогтоолын дагуу геологи, уул уурхай, газрын тосны салбарыг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан шилдэг тэргүүний хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг нь үнэлэн шагнахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Шагнуулах хүсэлтийг өмчийн аливаа хэлбэр харгалзахгүйгээр, сүүлийн 5 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага гаргаж болно.

1.3. Яамны “Жуух бичиг”-ээр дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэн шагнана. Үүнд:

1.3.1. Шагналд нэр дэвшиж байгаа хүн геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт 7-оос дээш жил тогтвор суурьшилтай ажилласан байна;

1.3.2. Тухайн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, найдвартай аюулгүй ажиллагааг хангах, өндөр үр ашигтай ажиллуулах, байгаль орчинд халгүй дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэхэд мэргэжил, ур чадвараа дайчлан өндөр амжилт гаргасан инженер техникийн ажилтан, албан хаагчид;

1.3.3. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургахад бодитой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ судалгааны ажилд шинэ нээлт бүтээл гаргасан багш, эрдэмтэд;

1.3.4. Салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, төр, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмадууд;

1.4. Засгийн газрын 1997 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Жуух бичиг”-ийн загварыг хэрэглэнэ.

Хоёр. Шагналыг мэдүүлэх

2.1 Шагнуулах хүний ажил байдлын тодорхойлолтыг тухайн хүнийг шагналд тодорхойлсон албан байгууллага гаргаж, шагнах үндэслэлийг тодорхой

бичиж, байгууллагын даргын албан тоотын хамт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлнэ.

2.2 Шагнуулах хүний материал нь нэгдүгээр хавсралтад дурдсан “Салбарын тэргүүний ажилтан”-аар шагнах журмын 2.1 дэх хэсэгт заасан материалыг бүрдүүлнэ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2018 оны 11 дугаар сарын 22 ны
өдрийн 14 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

САЛБАРЫН ТҮҮХЭН ОЙН "ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ААР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Тухайн салбарын түүхэн ойг тохиолдуулан олон жил үр бүтээлтэй ажилласан болон онцгой амжилт гаргасан тэргүүний хүмүүсийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын шийдвэрээр "Салбарын түүхэн ойн хүндэт медаль"-иар шагнахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Салбарын түүхэн ойн хүндэт медалиар дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэн шагнана. Үүнд:

1.2.1. Шагнуулах хүсэлтийг өмчийн аливаа хэлбэр харгалзахгүйгээр тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага гаргаж болно. Шагналд салбарт 5-аас дээш жил тогтвор суурьшилтай ажилласан хүнийг нэр дэвшүүлнэ;

1.2.2. Тухайн салбарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, өндөр үр ашигтай ажиллуулах, байгаль орчинд халгүй дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулсан ажилчид, албан хаагчдыг урамшуулж болно;

1.2.3. Салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургах үйлст бодит хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд шинэ нээлт бүтээл гаргасан багш, эрдэмтэд;

1.2.4. Салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан, төр, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмадууд;

1.3. Хүндэт медалиар шагнагдагсад хувийн дугаар бүхий үнэмлэх олгох ба медаль, үнэмлэхний загварыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батална.


Хоёр. Шагналыг мэдүүлэх

2.1. Шагнуулах хүний ажил байдлын тодорхойлолтыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж гаргаж, шагнуулах үндэслэлийг тодорхой бичин, байгууллагын даргын албан тоотын хамт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлнэ.

2.2. Тухайн салбарт он удаан жил ажилласан ахмад ажилтан, ажилчдыг яам, харьяа агентлаг, орон нутгийн удирдлагын саналыг үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын шийдвэрээр олгоно.

-----oOo-----

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2018 оны 11 дугаар сарын 20 ны
өдрийн 11 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт



“САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ТЭМДГЭЭР
ШАГНУУЛАХ ХҮНИЙ АНКЕТ

Зураг

1. Овог.....
2. Эцэг/эхийн/ нэр.....
3. Нэр.....
4. Хүйс.....
5. Төрсөн он, сар, өдөр.....
6. Регистрийн дугаар.....
7. Боловсрол, мэргэжил.....
8. Үндсэн захиргаа.....
9. Одоогийн харьяалал.....
10. Ажилладаг салбар.....
11. Ажилласан хугацаа: Нийт..... жил, үүнээс тухайн салбарт жил, тухайн хамт олны дотор жил
12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил

13. Урьд шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Шагнагдсан он

14. Шагнуулах үндэслэл: /Үүнд: тухайн хүний гаргасан ажлын амжилт, санаачлага, түүний үр дүн, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ технологи, санал санаачлага, бүтээл туурвил зэргийг суулийн 3 жилээр тусгана. Хэрэв шаардлагатай гэж үзвэл ажлын үзүүлэлт, холбогдох тооцоог хавсаргана./
-
-

15. Хамт олны санал:.....

16. Ямар шалтгаанаар шагнуулах.....

..... байгууллагын даргын гарын үсэг